

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ХАРЬЯА АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ХАМГААЛАЛТЫН АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ,
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.08.01

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2022 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн “Аюулгүй байдал хамгаалалтын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай” 07/22 тоот удирдамжийн хүрээнд Аюулгүй байдал хамгаалалтын албаны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер Ө.Мөнгөнжигүүр, аудитор А.Мөнх-Эрдэнэ, О.Сэндэр ИНҮТ-ийн Санхүү эдийн засаг төлөвлөлтийн газрын нягтлан бодогч Ж.Нямдэлгэр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2022 оны 7 дугаар сарын 26-ны өдрөөс 2022 оны 7 дугаар сарын 29-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Аюулгүй байдал хамгаалалтын албаны 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 6 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааны төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт болон анхан шатны баримтын бүрдүүлэлт, орлого, зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, түүний хяналт, цалин хөдөлмөрийн хөлсний тооцоолол, түүний эрх зүйн үндэслэл, холбогдох тайлан гаргалт, баталгаажуулалт, авлага, өглөгийн тооцооны бүртгэл хөтлөлт, түүний барагдуулалт, шилэн дансны хуулийн хэрэгжилт зэргийг нягталж шалгахгаас гадна зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Ажилтанд хөдөлмөр эрхлэлтийн харилцаа үүсэхээс өмнөх 11 өдрийн цалин бодож олгосон. Энэ нь ажлын цагийн тооцоог боловсруулсан мэргэжилтэн буруу гаргаж, нэгжийн дарга, хүний нөөцийн мэргэжилтэний хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалсан байна.

Ажлын цагийн тооцоог боловсруулсан тухайн нэгжийн мэргэжилтэн буруу гаргаж, Нэгжийн дарга, Захиргаа, санхүүгийн хэсэг хяналт сул байснаас цалингийн тооцоолол буруу хийгдэж, ингэснээр ээлжийн амралт, цалин хөлс давхацсан байна.

АБХА-ны цалингийн нягтлан бодогч нь удирдлагын тодорхойлж баталгаажуулсан үр дүнгийн нэмэгдэл олгох хуудасны дагуу цалинг 3 ажилтанд алдаатай олгосон байна.

ИНҮТ-ийн даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/410 дугаар тушаалаар баталсан Хүйтний нэмэгдэл олгох албан тушаалын жагсаалтад “Гадаа ажилладаг харуул пост” гэж заасан нь тодорхой бус бөгөөд уг тушаалд албан тушаал, ажлын байршил тодорхой заагаагүйгээс постонд ажилдаггүй ажилтнууд хүйтний нэмэгдэл авсан.

АБХА-ны 2022 оны эхний 1-6 дугаар сарын байдлаарх Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 47 мэдээллийг хуулийн хугацаанд нь мэдээлсэн боловч мэдээллийн үнэн зөв байдлыг шалгахад Захиргааны мэргэжилтний хариуцсан оруулах 14 шийдвэрийг мэдээлээгүй, түүнд тавигдах хяналт сул байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Аюулгүй байдал, хамгаалалтын албанд 5 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА